



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ**

2020 оны 09 сарын 08 өдөр

Дугаар 96

Мандалговь

┌ **Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл** ┐
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 30 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 4 дүгээр бүлгийн 4.3 дахь хэсгийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

Нэг: Улсын төсвийн хөрөнгө оруулалтын 2,264,343,672 /хоёр тэрбум хоёр зуун жаран дөрвөн сая гурван зуун дөчин гурван мянга зургаан зуун далан хоёр/ төгрөгийн санхүүжилтээр баригдсан Дэрэн сумын Ерөнхий боловсролын сургуулийн барилга, эд хөрөнгийг үндсэн хөрөнгийн дансанд хавсралтын дагуу бүртгэхийг зөвшөөрсүгэй.

Хоёр: Дэрэн сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал (Д.Мөнхтогтох)-д дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1. Комисс томилон хөрөнгө хүлээн авч бүртгэх ажлыг байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2020 оны 9 дүгээр сард багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх;

Гурав: Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (О.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ДАРГА *C. Cs.* С.СҮХБААТАР



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2020 оны 9 дүгээр сарын
08-ний өдрийн 2... тогтоолын хавсралт

Дэрэн сум Ерөнхий боловсролын сургуулийн үндсэн хөрөнгөнд
бүртгэх хөрөнгийн жагсаалт

№	Хөрөнгийн нэр	Хэмжих нэгж	Тоо	Нэг бүрийн үнэ	Дүн
1	Явган хүний зам	м ²	28	45,000	1,260,000
2	Гадна дулааны шугам	м	68,5	680,000	46,580,000
3	Гадна талбай	м ²	620	45,000	27,900,000
4	Сургуулийн барилга	ш	1	2,165,897,147	2,165,897,147
5	Гадна гэрэлтүүлэг	ш	8	550,000	4,400,000
6	Гадна сандал	ш	4	200,000	800,000
7	Бохирын шугам	м	5	1,400,000	7,000,000
8	Бохирын худаг	ш	1	10,506,525	10,506,525
Нийт дүн					2,264,343,672 /хоёр тэрбум хоёр зуун жаран дөрвөн сая гурван зуун дөчин гурван мянга зургаан зуун далан хоёр/ төгрөг